



### ҮЙЛ ЯВДАЛ

## 30 ГАРУЙ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД ЗАМЫН-ҮҮД БООМТОД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЖ БАЙНА



БНХАУ-ын Эрээний боомтод гацсан Монголын бизнес эрхлэгчдийн захиалгат барилгын материал, гэр ахуйн болон өргөн хэрэглээний бүтээгдэхүүн,

үйлдвэрийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, төрөл бүрийн түүвэр ачаа, сайжруулсан түлшний бэхжүүлэгч зэрэг хүлээгдэж байгаа барааг татан авах чиглэлд анхаарах, Замын-

Үүд боомтод бөөгнөрсөн тээврийн хэрэгслүүдийн дарааллыг багасгах, улаан бүсээс ирэх халдварын эрсдэлтэй иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлах, Эрээнээс орж ирсэн

ачааг авто машинаас галт тэргэнд ачиж төмөр замаар тээвэрлэх боломжийг нэмэгдүүлэх, экспорт, импортын ачааны татан авалттай уялдуулах Улаанбаатар болон бусад 21 аймгаас ирэх тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг яаралтай зохицуулах үүрэг, зорилго дор бүрэн эрхт төлөөлөгчөөр Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Л.Алтангэрэл, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, бригадын генерал Ц.Жавхланбаатар нарын томилогдсон бүрэлдэхүүнээс гадна Зэвсэгт хүчний Барилга-Инженерийн цэргийн удирдах газрын Цэргийн удирдах газрын Цэргийн мэргэжлийн удирдлагын хэлтсийн дарга, хурандаа Т.Батсайхан зэрэг алба хаагчид удирдлага зохион байгуулалтаар чиглэл өгч ажиллаж байна.

Мөн ЗХЖШ-ын даргын тушаалаар Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн ротын захирагч, ахлах дэслэгч М.Цогнэмэхээр ахлуулсан 25 алба хаагчид гурван нэгж техниктэйгээр Дорноговь аймгийн Замын-Үүд сумын дөрвөн шалган нэвтрүүлэх цэгт энэ сарын 7-ны өдрөөс хойш хяналт тавин явган болон машинтай эргүүлийн үүрэг гүйцэтгэж байна.

## ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ “БЭЛТГЭЛ ШАТНЫ СУРГАЛТ”-Г ЗОХИОН БАЙГУУЛАВ

Орхон аймгийн ЗДТГ-ын цэргийн штаб



Цэргийн штабын 2021 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу цэргийн дүйцүүлэх албаны сургалт, бэлтгэлийг батлагдсан хөтөлбөрийн дагуу цэргийн албыг 2021-2023 онуудад биеэр дүйцүүлэн хаах алба хаагч иргэдтэй цэргийн дүйцүүлэх албаны “Бэлтгэл шатны сургалт”-г Зэвсэгт хүчний 186

дугаар ангийн сургалтын төвийн материаллаг баазыг ашиглан зохион явууллаа.

Сургалт бэлтгэлийг зохион байгуулах үед гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргээр тогтоосон хорио цээрийг дэглэмийг сахин, Улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн



заавар зөвлөмжийг баримтлан ажиллаж, коронавируст халдвар /КОВИД/-ын тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажилсан юм.

Цэргийн дүйцүүлэх албаны сургалтыг аймгийн Засаг даргын захирамжаар баталсан төсвийн хүрээнд зохион байгуулж сургалтад

оролцогчдод шинэ хээрийн хувцас /малгай, китель, өмд/-зэргээр хангаж цэргийн штабын нөөц сургалтын материал хэрэгслийг үе шаттайгаар нэмэгдүүлэн сургалтын чанар үр дүн өмнөх жилээс ахиулан зорилгодоо хүрсэн амжилттайгаар сургалт бэлтгэлийг зохион байгуулсан юм.

Ахмад Д.НЯМЧУЛУУН

### ЦАГ АГААР

#### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 24	☁️ 14

#### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 29	☁️ 20

#### АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 35	☁️ 22

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.850.00	2.853.00
EUR 🇪🇺	3.380.00	3.395.00
CNY 🇨🇳	440.50	441.00
RUB 🇷🇺	37.20	39.40
JPY 🇯🇵	25.39	26.35
KRW 🇰🇷	2.40	2.56

### ЗУРХАЙ

Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой

**ЗУНЫ АДАГ ХӨХӨГЧИН ХОНЬ САРЫН ТАВАН ШАР ШАРАГЧИН МОГОЙ ӨДӨР**

Үс засуулбал:

Эрхтэн хурц болно.

Наран ургах, шингэх:

05.14-20.43

Барилдлага:

Түлэх

Шүтэн барилдлага:

Төрөн түгэхүй

Суудал:

Шороо

Аргын тооллын 7 сарын 20, Ангараг гараг. Билгийн тооллын 11, Онгоц одтой, шарагчин могой өдөр. Өдрийн наран 5 цаг 14 минутад мандан, 20 цаг 43 минутад жаргана. Тухайн өдөр үхэр жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмт хэрэг илрүүлэх, гэм буруутныг шийтгэх, сүм дуганыг сэргээх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, буг дарах, газрын ам бооход сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх, гөлөг тэжээх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрхтэн хурц болно.

### МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 148,424 +1171	ЭДГЭРСЭН 134,131 +3489	НАС БАРСАН 740 +6
-----------------------------------	---------------------------	----------------------

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 3878 +66	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 261 +29	ЭДГЭРСЭН 3549 +35
-----------------------------	--------------------------------	----------------------

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 190,526,225
Эдгэрсэн Нийт: 174,536,641
Нас барсан Нийт: 4,091,672



ЦАХИМ ШУУДАНД

ТОКИО-2020 олимпын наадамд оролцох “Алдар” спорт хорооны тамирчдыг цувралаар танилцуулж байна.

## БХЯ-НЫ ХАРЬЯА “АЛДАР” СПОРТ ХОРОО, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 337 ДУГААР АНГИЙН ТАМИРЧИН ОУХМ Ц.БЯМБАЖАВ

**Амжилтын товчоон:**

• 2006 оноос одоог хүртэл 14 жилийн туршид марафон гүйлтийн улсын болон олон улсын, тив дэлхийн аваргын тэмцээнүүдэд жил бүр тасралтгүй амжилттай оролцсон.

• “Гуанжоу-2010” Азийн наадамд марафон гүйлтийн төрлөөр эх орноо төлөөлөн амжилттай оролцсон.

• “Incheon-2014” Азийн наадамд 10000м-ийн зайн төрөлд эх орноо төлөөлөн амжилттай оролцсон.

• “Gwangju-2015” Зуны 28 дахь Оюутны Универсиад их наадамд хагас марафон гүйлтийн төрөлд эх орноо төлөөлөн амжилттай оролцож багийн дүнгээр дөрөвдүгээр байр.

• “Mungyeong-2015” Цэргийн дэлхийн аварга шалгаруулах 6 дахь наадамд марафон гүйлтийн төрлөөр эх орноо төлөөлөн амжилттай оролцсон.

• “РИО-2016” зуны олимпын 31-р наадамд марафон гүйлтийн төрлөөр эх орноо төлөөлөн амжилттай оролцсон.

• “Лондон-2017” Хөнгөн атлетикийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд марафон гүйлтийн төрлөөр эх орноо төлөөлөн амжилттай оролцсон.

• “Wuhan-2019” Цэргийн дэлхийн аварга шалгаруулах 7 дахь наадамд марафон гүйлтийн төрлөөр эх орноо төлөөлөн амжилттай оролцож дөрөвдүгээр байр.

• “ДОХА-2019” Хөнгөн атлетикийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд марафон гүйлтийн төрлөөр эх орноо төлөөлөн амжилттай оролцсон.

• “Токио-2020” зуны олимпын 32-р наадамд марафон гүйлтийн төрлөөр эх орноо төлөөлөн оролцох эрхээ аваад бэлтгэл сургуулилтаа амжилттай хийж байна.

• “Qingdao олон улсын марафон-2017” эх орноо төлөөлөн оролцож нэгдүгээр байр.

• 2017 онд марафон гүйлтийн ази тивийн аварга шалгаруулах тэмцээн-с хүрэл медаль.

• 2019 онд “KIX Senshu” Олон Улсын марафонд эх орноо төлөөлөн оролцож нэгдүгээр байр.

• Улаанбаатар олон улсын марафон гүйлтийн тэмцээнд 2010-2019 онуудад тасралтгүй оролцож тус бүр алт, мөнгө, хүрэл медальт байр.

• Монгол Улсын өсвөр үе, насанд хүрэгчдийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд 2006-2020 онуудад тасралтгүй оролцож тус бүр алт, мөнгө, хүрэл медальт байр.



• “Токио-2020” зуны олимпын 32-р наадамд марафон гүйлтийн төрлөөр эх орноо төлөөлөн оролцох эрхээ аваад бэлтгэл сургуулилтаа амжилттай хийж байна.

Коронавирусийн цар тахлын улмаас нэг жилээр хойшлогдсон “Токио-2020” олимпын наадам эхлэхэд цөөхөн хоног үлдлээ.

“Токио-2020” олимпын наадамд Монголын тамирчид байт харваа, буудлага, бокс, жудо, чөлөөт бөх, 3х3 сагсан бөмбөг, усанд сэлэлт, одон бөмбөг, хөнгөн атлетик, хүндийн өргөлт гэсэн спортын 10 төрөлд 43 эрх аваад байгаа юм. Үүнээс спортын 7 төрлөөр 12 тамирчин нь БХЯ-ны “Алдар” спорт

хорооноос оролцох эрхээ баталгаажуулаад байгаа юм. Тодруулбал,

1. МУХБ, МУГТ дэд хурандаа О.Гүндэгмаа-буудлага

2. ОУХМ ахлагч Э.Даваахүү-буудлага

3. ОУХМ ахлагч Б.Отгонболд- байт харваа

4. ОУХМ дэд ахлагч Б.Мөнхзаяа- марафон

5. ОУХМ ахлах ахлагч Ц.Бямбажав-марафон

6. ОУХМ ахлах ахлагч Б.Чинзориг- бокс

7. ОУХМ Х.Энхтуяа - паратаеквондо

8. ОУХМ Г.Болор-Эрдэнэ - паратаеквондо

9. МУГТ Ахлах дэслэгч М.Анхцэцэг- хүндийн өргөлт

10. ОУХМ дэслэгч Г.Алтанбагана,

11. МУГТ, дэслэгч Ө.Дүүрэнбаяр,

12. а х л а г ч Б.Ганхайч нар жудо бөхийн төрлөөр өрсөлдөхөөр бэлтгэл сургуулилтаа хэдий хангаад байгаа бөгөөд Монгол Улс, Зэвсэг хүчнээ төлөөлөн оролцох нийт тамирчдадаа амжилт хүсье.

ЦАГ ҮЕ

## ОЛИМПЫН НААДМЫГ ВИРТУАЛ БОДИТ ОРЧИНД ҮЗЭХ БОЛОМЖИЙГ ОЛГОЖЭЭ



Токио-2020 Олимпын наадмын ихэнх арга хэмжээ үзэгчгүй зохион байгуулагдах билээ. Үүнтэй холбогдуулан Японы мэдээлэл технологийн нэгэн компани ажиглалтаа Олимпын наадмыг хамт суун үзэх боломжийг олгожээ.

Тус компани ажиглалтаа Олимпын наадмыг биеэр үзэж буй

мэт мэдрэмж төрүүлж, арга хэмжээг гэрээсээ аюулгүй үзэх боломжийг олгохын тулд виртуал бодит орчинд цэнгэлдэх бүтээсэн байна. Ингэснээр ажиглалтаа наадмын арга хэмжээг хамт үзэж, сэтгэгдлээ хуваалцаж, тамирчдыг цахим зурвасаар дэмжих боломжтой болжээ.

Коронавирусийн цар тахлаас шалтгаалан өнгөрсөн оны хоёрдугаар сараас эхлэн компанийн ажиглалтаа алсын зайнаас ажиллажээ. Иймд уг виртуал систем нь тэднийг эргэн нэгдэхэд тусална гэдэгт итгэлтэй байгаагаа компанийн удирдлагууд илэрхийлсэн байна.

Эх сурвалж: NHK

## ФАЙЗЕРЫН ХОЁР ДАХЬ ТУНГИЙН ДАРХЛААЖУУЛАЛТ ЭХЭЛЛЭЭ



Файзер вакцины нөөц дууссантай холбоотойгоор тус аймагт 12-оос дээш насны хүүхдүүд, жирэмсэн эмэгтэйчүүд, эрүүл мэндийн туйлын эсрэг заалттай иргэдэд хийж байсан дархлаажуулалтыг хэд хэд хэсгээр завсарлаад байсан. Тэгвэл өнөөдрөөс дээрх иргэдийн хоёр дахь тунгийн

дархлаажуулалтыг эхлүүлээ. Тодруулбал, 6 дугаар сарын 29-нд 2340 хүн тун вакциныг татан авчээ. Сум тус бүрт нэг цэгээр дамжуулан хийж байгаа уг ажилд иргэд болон хүүхдүүдийн хамрагдах идэвх сайн байна. Одоогоор вакцины хариу урвалтай холбоотой мэдээлэл бүртгэгдээгүй байна гэв. Вероселл болон

файзер вакцины ерөнхий хамрагдалтыг авч үзвэл хамрагдвал зохих иргэдээс эхний тунд 41816 буюу 89,6 хувь, хоёр дахь тунд 37131 буюу 79,6 хувь нь хамрагджээ.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 12-оос дээш насны 46671, 16, 17 насны 1750 орчим хүүхэд бий.

Эх сурвалж: ЭМЯ

## 9 ДҮГЭЭР САРЫН 1-НД ТАНХИМААР ХИЧЭЭЛ ЭХЛҮҮЛЭХЭЭР БЭЛТГЭЖ БАЙНА



БШУЯ-наас 9 дүгээр сарын 1-нд танхимаар хичээл эхлүүлэхээр бэлтгэл ажлаа хангаж байна. Энэ тухай Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан

мэдээлэхдээ, "Сургууль хичээл эхлүүлэх хугацаа Боловсролын хуулийн дагуу зохицуулагд. Тийм учраас бид хуулиа хэрэгжүүлнэ. Гэхдээ 9 дүгээр сарын 1 гэхэд "Ковид-19"-ийн нөхцөл байдал

сайжрах уу эсвэл муудах уу гэдгийг хэлэхэд эрт байна. Одоогоор 12-17 насны хүүхдийн 70 орчим хувь, ЕБС-ийн багш нарын 80 орчим хувь нь вакцины хоёр дахь тунгаа аваад байна. Намрын хичээлийн жилийг хуулийн хугацаанд нээхийн тулд чармайн ажиллана. Гэхдээ эцсийн шийдвэрийг Засгийн газар гаргана. Бид энэ жилийн 9 дүгээр сарын 1-нд хичээлээ эхлүүлэхгүй бол хоёр жилийн турш танхимын хичээлийг бүрэн хаасан цөөн хэдэн улсын тоонд орохоор байна. Хичээлийн хоцрогдол маш их үүссэн. Нэгэнт бид ковидтой дасан зохицон амьдрахаас хойш хичээлийн жилийн хугацаанд нь танхимаар эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байгаа" гэв.

Эх сурвалж: БШУЯ



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ  
Батлан хамгаалах яам  
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС  
"Соёмбо" сонин

\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.  
\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.  
\* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Оффисуудын ордон Индекс: 10018  
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn  
Утас: 70001029, 3412 (дотуур)